

ХАДГАЛАМЖИЙН ЗАХЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Нийт хадгаламжийн хэмжээ 2011 оны 11 дүгээр сард 3.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 60.0 хувиар өссөн байна. Хадгаламжийн нэрлэсэн жигнэсэн дундаж хүү 10.5 хувь, хадгаламжийн бодит жигнэсэн дундаж хүү 2.6 хувь, жилийн инфляци 12.3 хувь байлаа.

Хадгаламжийн хүү, хэмжээ


Сүүлийн жилүүдэд хадгаламжийн нэрлэсэн жигнэсэн дундаж хүү аажмаар буурсаар байна. 2008 оны эхнээс инфляци хэт хурдацтай өсч улмаар хадгаламжийн бодит хүү сөрөг утгатай болжээ. Энэ нь дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал манай улсын санхүүгийн зах зээлд ихээхэн хүндээр туссантай холбоотой байна. Харин эдийн засгийн өсөлтийн үеүдэд нэмэгдэж байсан хадгаламж дээрх хямралаас үүдэлтэйгээр бодит хүү буурсан, эх үүсвэр их хэмжээгээр гадагшилсан, Анод банк дампуурснаас банкинд итгэх итгэл алдарсан зэргээс 2008 оны сүүлийн 3 сард буурсан хэдий ч 2009 оны 1 дүгээр сараас эргэн өсч 2011 оны 11 дүгээр сард 3.7 их наяд төгрөгт хүрсэн байна.

Инфляци 2008 оны 8 дугаар сард хамгийн оргил (33.7%) цэгтээ хүрч байснаа буурсаар 2009 оны 9 дүгээр сард дефляцитай гарч хадгаламжийн бодит хүү хамгийн өндөр түвшиндээ буюу 15.1 хувьд хүрсэн байна. Ийнхүү бодит хүү өссөн, төр банкинд дахь хадгаламжинд баталгаа гаргасан зэргээс хадгаламж тогтвортой өсөх болов.

Инфляцийн түвшин 2009 оны 9 дүгээр сараас эргээд өссөнтөй холбоотойгоор бодит хүү буурав. Ялангуяа 2010 оны 6,

2010 оны 11-ээс 2011 оны 2 дугаар саруудад инфляци өндөр байснаас бодит хүү сөрөг утгатай гарч байжээ. Инфляци 2011 оны 10 сард 12.6 хувьд хүрч улмаар бодит хүү бууран 1.4 хувьд, 11 дүгээр сард инфляци 12.3 хувьд хүрч бодит хүү сөрөг утгатай (-0.1%) болжээ. Энэ үеийн хадгаламжийн хэмжээг авч үзвэл хадгаламжийн өсөлтийн хувь өмнөх сараас 3.0 нэгж хувиар буурсан байна.

Зураг1: Хадгаламж, хадгаламжийн бодит хүү




Эх үүсвэр: Монголбанк

Хадгаламжийн захын сегментчлэл, хадгаламж эзэмшигчдээр

Банкны салбарын хэмжээнд 2011 оны 10 дугаар сарын байдлаар нийт хадгаламж эзэмшигчдийн 99.4% нь 50 сая төгрөг хүртэл, 0.3% нь 50-100 сая төгрөг, 0.3% нь 100 сая төгрөгөөс дээш төгрөгийн хадгаламж эзэмшдэг байна. Хадгаламжийн дүнгээр 52.4% нь 100 сая төгрөгөөс дээш, 38.0% нь 50 сая төгрөг хүртэл, 9.6% нь 50-100 сая төгрөгийн хадгаламжтай байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн хамгийн бага буюу 0.3 хувь нь 100 сая төгрөгөөс дээш хадгаламж эзэмшигч байгаа хэдий ч 100 сая төгрөгөөс дээш хадгаламжийн дүн нийт хадгаламжийн дийлэнх хувийг бүрдүүлсэн байна.

Зураг 2: Хадгаламжийн ангиллын нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь



Хадгаламжийн захын сегментчлэл, банкуудаар

Банкуудын зах зээлийн төвлөрлийг 2011 оны 11 дүгээр сарын байдлаар тооцож үзэхэд том 4 банкны зах зээл дэх төвлөрлийн харьцаа $CR_4=77.6^1$, хадгаламжийн зах зээл дэх төвлөрлийн харьцаа $CR_4=84.3$ байгаа нь хадгаламж нэлээд төвлөрсөн байгааг харуулж байна (Хүснэгт 1). Өөрөөр хэлбэл, нийт хадгаламжийн 84.3 хувь нь том 4 банкинд оногдож байгаа бол 12.1 хувь нь дундаж банкуудад, үлдсэн 6.0 хувь нь жижиг банкуудад байршиж байна.

Хүснэгт 1. Банкны салбарын нийт актив болон нийт хадгаламжид эзлэх хувийн жин (2011.09.30-ны байдлаар)

Банкууд	Нийт актив	Хувийн жин	Бүлгийн жин	Нийт хадгаламж	Хувийн жин	Бүлгийн жин
Том 4 банк	ХААН	1,954,891,091.0	23.1		966,102.84	25.5
	Голомт	2,086,230,874.2	24.3	77.6	1,166,204.65	30.8
	ХХБ	1,859,114,055.4	22.0		759,637.13	20.0
	Хадгаламж	684,772,434.3	8.1		305,775.99	8.1
Дундаж банк	УБХ	429,860,398.3	5.1		72,190.75	1.9
	ХАС	730,812,892.2	8.6	16.4	295,338.91	7.8
	Төрийн	225,841,133.8	2.7		90,458.67	2.4

Эх үүсвэр: Монголбанк

Банкуудын өрсөлдөөний хэлбэрийг Herfindahl-Hirschman index-ээр тооцож үзэхэд $HHI=1271.7$ буюу манай банкны

$CR_k = \frac{\sum_{i=1}^k A_i}{\sum_{i=1}^n A_i}$ Энд: k – төвлөрлийн хэмжээг тооцох банкны тоо, n – нийт банкны тоо, A_i – тухайн банкны активын хэмжээ.

систем монополист өрсөлдөөнт зах зээл²-ийн шинжийг агуулж байгаа нь харагдаж байна. Ийм төрлийн зах зээлийн гол шинж нь бүтээгдэхүүний ялгаварлал бөгөөд банкууд зээл болон хадгаламжийн бүтээгдэхүүний ялгаварлал дээр өрсөлдөж байна. Энэ нь хадгаламжийн шинэ төрлийн бүтээгдэхүүнийг бий болгож, иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэгцээнд нь тохирсон хадгаламжийн бүтээгдэхүүнийг бий болгоход эерэг нөлөөтэй.

II. ХАДГАЛАМЖИЙН ХҮҮНИЙ САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Арилжааны банкуудын дунд 2011 оны 10 дугаар сард хадгаламжийн хүүний талаар санал асуулга (Хавсралт 1) явуулж үр дүнг нэгтгэн танилцуулж байна. Тус санал асуулга нь нийт 13, үүний дотор нээлттэй 6, сонголт хийх 7 асуулгаас бүрдсэн. Банкуудын өөрсдийнх нь байр суурь чухал тохиолдолд асуултын нээлттэй хэлбэрийг сонгов. Санал асуулгад нийт 13 банк хамрагдсан бөгөөд Чингис хаан банк хадгаламж татдаггүй гэсэн үндэслэлээр оролцоогүй. Санал асуулгыг боловсруулахдаа том банкинд Хаан, Голомт, ХХБ, Хадгаламж банкуудыг, дундаж банкинд ХАС, Улаанбаатар хотын болон Төрийн банкуудыг, бусад банкуудыг жижиг гэж ангилав.

Санал асуулгын үр дүнг асуулт бүрээр авч үзвэл:

1. Танай банкнаас хадгаламжийн хүүг тогтооход ямар хүчин зүйлс хамгийн их нөлөөлдөг вэ?

² Америкийн шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх газраас гаргасан ангиллаар.

Хадгаламжийн хүүний түвшинд эх үүсвэрийн зардал, инфляцийн түвшин, өрсөлдөөн, банкны системийн илүүдэл нөөцийн хэмжээ, хадгаламж эзэмшигчдийн үйл хөдлөл, хөрөнгийн захын хөгжил зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байдаг. Эдгээрээс хамгийн чухал нь инфляцийн хүлээлттэй холбоотой зах зээлийн эрсдэл юм.

Том банкууд хадгаламжийн хүүгээ тогтоохдоо зах зээлийн өрсөлдөөн, татан төвлөрүүлэлтийн хэрэгцээ шаардлага, банкны өсөлтийн болдлого, эх үүсвэрийн дундаж зардал, ашигт ажиллагаа, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан үздэг гэж хариулсан байна. Харин дундаж болон жижиг банкууд зах зээлийн нөхцөл байдал, бусад банкны хадгаламжийн хүү, заавал байлгах нөөцийн хэмжээ, эх үүсвэрийн өртгийг харгалзан үзэж хадгаламжийн хүүгээ тогтоодог гэж хариулжээ.

2. Сүүлийн жилүүдэд зээлийн хүүтэй харьцуулахад хадгаламжийн хүү дорвитой буурахгүй байгаа үндсэн шалтгааныг нэрлэнэ үү?

Хадгаламжийн хүү дорвитой буурахгүй байгаа нь инфляцийн хүлээлт, хадгаламжийн захын сегментчлэлтэй юуны түрүүнд холбоотой юм.

Тус асуултанд банкуудын дийлэнх хувь нь инфляцийн хүлээлт өндөр, тогтвортой урт хугацаатай эх үүсвэр татах боломжгүй, өөрийн хөрөнгө бага, зээл олголт их байсантай холбоотой эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн их байгаагаас хадгаламж өндөр хүүгээр татах сонирхолтой зэргээс шалтгаалж хадгаламжийн хүү буурахгүй байгаа гэж үзсэн байна. Мөн банкны салбарт гарсан хүндрэлүүд иргэдийн банкны салбарт итгэх итгэлд нөлөөлсөн гэж хариулжээ.

3. Хадгаламжийн дундаж хугацаа богино байгаа нь юутай холбоотой вэ?

Хадгаламжийн дундаж хугацаатай холбоотой асуултанд дийлэнх банкууд эдийн засгийн тогтворгүй байдал, инфляцийн түвшин тодорхой бус, иргэдийн банкинд итгэх итгэл сул байгаа нь хадгаламжийн дундаж хугацаа богино байгаагийн үндсэн шалтгаан хэмээн хариулжээ. Том банкуудын хувьд эдийн засгийн байдал, инфляцийн хүлээлт өндөр байгаагаас иргэд урт хугацаагаар хадгаламж байршуулах сонирхол бага, өрхийн орлого тогтмол урт хугацаатай биш, эрсдэл өндөр, харилцагчийн сэтгэл зүйтэй холбоотой гэж үзжээ. Дундаж болон жижиг банкууд, инфляцийн хүлээлт өндөр, иргэдийн банкны системд итгэх итгэл сул байгаагаар холбон үзэж байна.

Эндээс дүгнэхэд банкууд инфляцийн хүлээлт, өрхийн орлого тогтмол урт хугацаатай биш, мөнгөн хөрөнгийн төлөвлөлт богино, эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэлтэйгээр хадгаламжийн хугацаа богино байна гэж үзэж байхад, дунд болон жижиг банкууд ихэнхдээ иргэдийн банкинд итгэх итгэл сул байгааг онцолсон байна.

4. Танай банк хадгаламжийн хэмжээг хэрхэн ангилдаг вэ?

Тус санал асуулгаар хадгаламжийн хэмжээг банкууд хэрхэн ангилж байгааг тогтоохыг зорилго. Төрөөс харилцах, хадгаламжид баталгаа гаргаж буй тогтолцоог хадгаламжийн даатгалаар өөрчлөхөд хадгаламжийн хэмжээний талаар мэдээлэл шаардлагай. Даатгалын тогтолцоотой улс орнуудад хадгаламжийн хэмжээг бага, дунд, том хэмээн нэгдсэн байдлаар ангилан, үүн дээр тулгуурлан даатгалд бүх хадгаламжийг

хамруулах уу аль эсвэл тодорхой дүн хүртэл хамруулах уу гэдгээ шийдвэрлэдэг байна.

Хадгаламжийн хэмжээг хэрхэн ангилдаг вэ гэсэн асуултанд банкуудын 15.4% нь 0.5-1.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй хадгаламж, 7.7% нь 500 сая төгрөгөөс дээш дүнтэй хадгаламж, 7.7% нь 200 сая төгрөг хүртэл дүнтэй хадгаламж, 15.4% нь 100 сая төгрөгөөс дээш дүнтэй хадгаламж, 30.8% нь 50 сая төгрөгөөс дээш дүнтэй хадгаламж, 7.7% нь 20 сая төгрөг хүртэл дүнтэй хадгаламжийг том дүнтэй хадгаламж гэж ангилдаг байна. Харин 7.7% нь 1.0 тэрбум төгрөг хүртэл, 7.7% нь 500 сая төгрөг хүртэл, 7.7% нь 200 сая төгрөг хүртэл, 15.4% нь 100 сая төгрөг хүртэл, 38.5% нь 50 сая төгрөг хүртэл, 7.7% нь 5.0 сая төгрөг хүртэл дүнтэй хадгаламжийг дундаж дүнтэй хадгаламж, 7.7% нь 500 сая төгрөг хүртэл, 7.7% нь 100 сая төгрөг хүртэл, 23.1% нь 50 сая төгрөг хүртэл, 7.7% нь 15 сая төгрөг хүртэл, 15.4% нь 5 сая төгрөг хүртэл, 23.1% нь 1 сая төгрөг хүртэл дүнтэй хадгаламжийг бага дүнтэй хадгаламж гэж ангилдаг байна. Кредит, Төрийн банкууд хадгаламжийн хэмжээгээ ангилдаггүй гэж хариулжээ. Нийт хадгаламжийн 50 сая төгрөг хүртэл хадгаламжинд даатгалын тогтолцоо бүрэн үйлчилнэ гэж үзвэл нийт хадгаламж эзэмшигчдийн 99.4 хувь буюу хадгаламжийн үлдэгдлийн 37.9 хувь нь хамрагдах боломжтой байна


5. Том хадгаламж эзэмшигчдээ бусад банкинд алдахгүйн тулд танай банк харьцангуй өндөр хүү амлах тохиолдол гардаг уу?

Нийт хадгаламж эзэмшигчдийн 0.3% нь нийт хадгаламжийн үлдэгдлийн 52.5%-ийг бүрдүүлж байгааг дээр харуулсан билээ. Ийм нөхцөлд 100 сая төгрөгөөс дээш хадгаламжтай том хадгаламж эзэмшигчид банктэй гэрээ байгуулахдаа давуу

эрхтэйгээр оролцдог байж болох юм. Том хадгаламж эзэмшигчдийг татахын тулд банкууд өндөр хүү амладаг эсэхийг тус асуултаар тодруулах зорилготой байв.

Банкуудын 76.9% нь том хадгаламж эзэмшигчдээ бусад банкинд алдахгүйн тулд **өндөр хүү** амлах тохиолдол гардаг хэмээн хариулсан нь энэхүү таамаглалыг баталгаажуулж байна. Том банкуудын 75 хувь, жижиг банкуудын 86 хувь нь, дундаж банкуудын 67 хувь нь ийм зүйл байдаг гэж хариулжээ.

Асуулт 5: Том хадгаламж эзэмшигчдээ бусад банкинд алдахгүйн тулд танай банк харьцангуй өндөр хүү амлах тохиолдол гардаг уу?




6. Хадгаламжийн хүүг өөрчлөх/хэвээр нь үлдээх шийдвэр хэр тогтмол гардаг вэ?

Энэ асуултаар банкууд хүүгээ өөрчлөхдөө бусад банкуудын үйл хөдлөлийг дагаж байна уу, аль эсвэл тодорхой давтамжтайгаар шийдвэрээ гаргаж байна уу гэдгийг тодорхойлохыг зорьсон. Бусад улсуудын хувьд актив, пассивын удирдлагатай холбоотой энэхүү чухал асуудлыг банкууд ихэвчлэн тодорхой давтамжтайгаар байнга хэлэлцэх хандлагатай байдаг бол томоохон банкууд бусдын үйл хөдлөлийг илүүтэйгээр ажигладаг байна.

Банкуудын 31% нь хадгаламжийн хүүний асуудлыг улирал болгон авч үздэг бол 69% нь тухайн үеийн эдийн засаг, санхүүгийн

орчны нөхцөл байдлаас шалтгаалдаг хэмээн хариулжээ.

Асуулт 6: Хадгаламжийн хүүг өөрчлөх/хэвээр нь үлдээх шийдвэр хэр тогтмол гардаг вэ?




Судалгаанд хамрагдсан том болон дундаж банкуудын 86%, жижиг банкуудын 50% нь тодорхой давтамжгүйгээр, тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан шийдвэрээ гаргадаг гэжээ. Жижиг банкуудын 50% нь, том болон дундаж банкуудын 14% нь **улирал бүр** хадгаламжийн хүүтэй холбоотой шийдвэр гаргадаг гэж хариулсан байна. Санал асуулгад оролцсон бүх банкууд хадгаламжийн хүүг өөрчлөх буюу хэвээр нь үлдээх шийдвэрийг **сар бүр** авч хэлэлцдэггүй гэж хариулжээ.

7. Өнөөгийн нөхцөлд хадгаламжийн хүү буурлаа гэхэд зээлийн хүүнд өөрчлөлт орох уу?

Өнөөгийн нөхцөл байдалд хадгаламжийн хүү буурлаа гэхэд нийт банкуудын 46% нь зээлийн хүүгээ бууруулна, 38% нь зээлийн хүү бууртлаа нэлээдгүй хугацаа орно, 15% нь зээлийн хүүнд өөрчлөлт оруулахгүй гэж хариулжээ.

Асуулт 7: Өнөөгийн нөхцөлд хадгаламжийн хүү буурлаа гэхэд зээлийн хүүнд өөрчлөлт орох уу?



8. Танай банк хадгаламжийн хүүгээ бууруулахад хадгаламжийн нийт хэмжээнд ямар өөрчлөлт гарч байсан бэ?

Хадгаламжийн захын эрэлт, хүүнээс хамаарсан мэдрэмжийг ерөнхий байдлаар үнэлэхийн тулд тус асуултыг банкуудаас лавласан болно.


Бүх банкууд хүүний түвшин буурахад хадгаламжийн хэмжээ харьцангуй тогтвортой байсан гэж хариулжээ.

9. Зарим банк бодит үндэслэлгүйгээр хадгаламжийн хэт өндөр, зах зээлийн бус хүү санал болгоод эхэлбэл танай банк ямар хариу үйлдэл хийх вэ?

Банкууд олон улсын санхүүгийн зах зээлд гарцгүй, нөгөө талаас иргэд, аж ахуйн нэгжээс хадгаламж, харилцах татах нь цорын ганц эх үүсвэртэй учир хадгаламжийн хүүгээр хоорондоо өрсөлдөж эх үүсвэрээ татан төвлөрүүлж байгаа билээ. Үүнээс шалтгаалж зарим нэг банкууд хадгаламжийг өндөр хүүгээр татан төвлөрүүлэн зээлийн хүүг өндрөөр тогтоосон байдаг. Гэвч томоохон банкууд хадгаламжийн хүүгээ бууруулахад энэ нь хадгаламжийн хэмжээнд нь сөргөөр нөлөөлөөгүй байна.

Банкуудын 85% нь ийм байдал үүсвэл хүүндээ өөрчлөлт оруулахгүй, хэмээн хариулсан бол 15% нь тодорхой хариулт өгөхөөс татгалзсан байна.

Асуулт 9: Зарим банк бодит үндэслэлгүйгээр хадгаламжийн хэт өндөр, зах зээлийн бус хүү санал болгоод эхэлбэл танай банк ямар хариу үйлдэл хийх вэ?



Том болон дундаж банкууд 100%, жижиг банкуудын 66.6% нь хадгаламжийн хүүндээ өөрчлөлт оруулахгүй гэсэн бол жижиг банкуудын 33.3% нь тодорхой хариулт өгөхөөс татгалзсан байна.

10. Танай банкны хадгаламжийн хүүний талаарх 2012 оны төсөөллөөсөө бидэнтэй хуваалцана уу?

Тус асуулт нь банкуудын инфляцийн хүлээлт ямар байгааг үнэлэхэд чиглэгдсэн юм.

Санал асуулгад оролцсон банкуудын 23% нь хадгаламжийн хүү 2012 онд буурна гэсэн хүлээлттэй байгаа бол 31% нь хүү өөрчлөгдөхгүй, 46% хүү нэмэгдэнэ гэж хариулжээ.

Том банкуудын 50 хувь нь хадгаламжийн хүүг бууруулах, 25 хувь нь хэвээр нь үлдээх үлдсэн 25% нь хадгаламжийн хүүгээ нэмэгдүүлэх сонирхолтой байгаа бол дундаж банкууд бүгдээрээ хадгаламжийн хүүгээ нэмэгдүүлнэ гэжээ. Харин жижиг

банкуудын 1/3 нь өөрчлөлт оруулахгүй, 1/3 нь бууруулна, 1/3 өсгөнө гэж хариулжээ.

11. Банкуудын хадгаламжийн хүүг бууруулахын тулд Монголбанк нэн түүрүүнд ямар арга хэмжээ авах ёстой вэ?

Монголбанк инфляцийн түвшинг ойрын жилүүдэд бага, тогтвортой түвшинд барьсан тохиолдолд инфляцийн хүлээлтийг бууруулах боломж бүрдэнэ. Инфляци, түүний хүлээлт тогтворжсоноор хадгаламжийн хүү буурах эдийн засгийн суурь нөхцөл бүрдэнэ.

Банкууд Монголбанк инфляцийг тогтвортой бага түвшинд барих, бодлогын хүүг бууруулах, хадгаламж, зээлийн харьцаанд шинэжилсэн стандарт бий болгох, иргэдэд банкны үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл өгөх, төрийн үйлчилгээний мөнгөн хөрөнгийг банкуудад хүүгүй байршуулах, хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох, бодлогоор дэмждэг эдийн засгийн салбарт олгогдож байгаа зээлүүдийн хүүг бууруулах, тогтвортой бага зардалтай эх үүсвэр татахад банкуудад дэмжлэг үзүүлэх, хямд үнэтэй, урт болон дунд хугацааны эх үүсвэрээр хангах шаардлагатай байгааг дурьджээ.

12. Хадгаламжийн хүүн дээр Монголбанкнаас дээд хязгаар тогтоох нь зөв үү?

Хадгаламжийн хүүнд Монголбанкнаас дээд хязгаар тогтоохыг банкуудын 15% нь дэмжиж, 69% нь дэмжээгүй байна. Харин үлдсэн 15% мэдэхгүй гэж хариулжээ.

Дээд хязгаар тогтоохыг том болон дундаж банкууд бүгд, жижиг банкуудын 33.3 хувь нь дэмжээгүй байна.

13. Татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн зардлыг хямдруулахын тулд танай

банкнаас ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?

Тус асуултаар банкууд эх үүсвэрээ хямдруулах дотоод, гадаад боломжийг хэрхэн эрэлхийлж байгааг тодорхойлох зорилттой байв.

Банкууд хөрөнгө оруулагчдаасаа бага хүүтэй эх үүсвэр татах, бэлэн бус төлбөр тооцоог нэмэгдүүлэх, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх зардал багатай эх үүсвэрийн хувийн жингээ нэмэгдүүлэх, зэрэглэлээ нэмэгдүүлж олон улсын захаас татдаг эх үүсвэрийн зардлыг хямдруулах, богино хугацаатай эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах, сул чөлөөтэй эх үүсвэрээр үнэт цаас худалдаж авах, харилцах, хадгаламжийн үйлчилгээний нэр төрлийн нэмэгдүүлэн, нэвтрүүлэх талаар судалж байгаагаа банкууд дурьджээ.

ЗЭЭЛ, ЗЭЭЛИЙН ХҮҮ

Нийт зээлийн хэмжээ 2011 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар 5.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 74.7 хувиар өсчээ. Зээлийн жигнэсэн дундаж хүү 16.1 хувь байлаа.


Эдийн засгийн өсөлтийн үеүдэд зээлийн хэмжээ хадгаламжийн адил өсч байснаа хямралын улмаас банкууд эх үүсвэрийн дутагдалд орж 2008 оны 4 дүгээр улирлаас эхлэн 2009 оны дундуур хүртэл зээлийн тасалдал бий болж зээлийн хэмжээ 2.7 их наяд төгрөгөөс 2.5 их наяд төгрөг болтол буурчээ.

Монголбанк, Засгийн газраас шат дараатайгаар арга хэмжээ авсан нь банкны салбарыг хямралаас сэргийлж, учирсан хүндрэлийг саармагжуулан, улмаар зээлийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөгөөс төдийлөн буураагүй юм. Үүний зэрэгцээ эдийн засгийн байдал сэргэж, банкууд эх үүсвэрийн тасалдлаасаа гарч, зээл олголт нэмэгдэн, зээлийн хэмжээ өссөөр байна.

Уул уурхайн салбарыг дагасан хөрөнгийн урсгал эрс нэмэгдсэнээс банкны салбарын эх үүсвэр өссөн, эдийн засаг сэргэж, үйл ажиллагаа идэвхжин зээлийн эрэлт нэмэгдсэн зэргээс банкууд зээл олголтоо нэмэгдүүлж зээлийн хэмжээ 2010 оны эцсээс эхлэн эрс нэмэгдсээр байна.

Харин хүүг авч үзвэл, зээлийн хүүний хандлага хадгаламжийн хүүний хандлагатай адил буурсан байна.

Зураг 10: Зээл, инфляци, хадгаламж зээлийн хүү



ЗЭЭЛИЙН ХҮҮНИЙ САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Зээлийн хүүний санал асуулга нь нийт 4 нээлттэй, 7 сонголт хийх асуулгаас бүрдсэн. Банкуудын өөрсдийнх нь байр суурь чухал тохиолдолд асуултын нээлттэй хэлбэрийг хадгаламжийн хүүний асуулгатай адил сонгов. Санал асуулгад нийт 14 банк хамрагдсан байна. Санал асуулгыг боловсруулахдаа том банкинд ХААН, Голомт, ХХБ, Хадгаламж банкуудыг дундаж банкинд, ХАС, Улаанбаатар хотын, Төрийн банкуудыг, бусад банкуудыг жижиг гэж ангилав.

Санал асуулгын үр дүнг асуулт бүрээр авч үзвэл:

1. Танай банкнаас зээлийн хүүг тогтооход ямар хүчин зүйлс хамгийн их нөлөөлдөг вэ?

Зээлийн хүүг тогтооход эх үүсвэр, зээлтэй холбогдон гарч буй зардлуудад үндсэлдэг. Судалгаанд хамрагдсан хариултуудын хандлага ерөнхийдөө төстэй байсан бөгөөд дийлэнх банкууд эх үүсвэрийн зардал, эрсдэлийн түвшин, өрсөлдөгч банкуудын зээлийн хүү, үйл ажиллагааны зардал зэргийг харгалзан үзэж зээлийн хүүгээ тогтоодог гэжээ.

2. Зээлийн дундаж хугацаа богино байгаа нь юутай холбоотой вэ?

Том банкууд зээлийн дундаж хугацаа богино байгаа нь эх үүсвэрийн дундаж хугацаа богино, ихэнх зээлүүд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулагддаг, эдийн засаг тогтвортой биш, эрсдэлийн түвшин өндөр байгаатай холбоотой гэж үзсэн байна. Харин дундаж, жижиг банкууд хадгаламжийн хугацаа богино, зээлдэгч нарын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад хүчин зүйлс их, мөн эх үүсвэрийн дундаж хугацаа богино, худалдааны салбарт дийлэнх зээл олгогдсон тул богино хугацаатай олгосон гэжээ.


3. Танай банк зээлийн хэмжээг хэрхэн ангилдаг вэ?

Зээлийн хэмжээг хэрхэн ангилдаг вэ гэсэн асуултанд банкуудын 7.1% нь 4 тэрбум төгрөгөөс дээш, 7.1% нь 2 тэрбум төгрөгөөс дээш, 35.7% нь 1 тэрбум төгрөгөөс дээш, 14.3% нь 500 сая төгрөгөөс дээш, 7.1% нь 100 сая төгрөгөөс дээш, 21.4% нь 50 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийг том дүнтэй зээл гэж ангилдаг гэж хариулжээ. Дундаж дүнтэй зээлд 4 тэрбум төгрөг хүртэл зээлийг оруулдаг гэж нийт банкуудын 7.1% нь, 1 тэрбум төгрөг хүртэл гэж 21.4% нь, 500 сая төгрөг хүртэл гэж 28.6% нь, 300 сая төгрөг хүртэл гэж 14.3% нь, 100 сая төгрөг хүртэл гэж 7.1% нь, 50 сая төгрөг хүртэл гэж 21.4% нь тус тус үзсэн байна. Харин 7.1% нь 500 сая төгрөг хүртэл, 7.1% нь 150 сая төгрөг хүртэл, 7.1% нь 100 сая төгрөг хүртэл, 28.6% нь 50 сая төгрөг хүртэл, 7.1% нь 30 сая төгрөг хүртэл, 42.9% нь 6-20 сая төгрөг хүртэл зээлийг бага дүнтэй зээл гэж ангилдаг байна.

4. Том зээлдэгчдээ бусад банкинд алдахгүйн тулд танай банк зээлийн хүүний хөнгөлөлт үзүүлдэг үү?

Найдвартай зээлдэгчээ алдахгүйн тулд бага хүү амлах явдал байдаг эсэхийг лавлахаар уг асуултыг оруулсан бөгөөд судалгааны дүнгээр банкуудын 79 хувь нь том зээлдэгч нартаа бага хүү амлах тохиолдол гардаг гэжээ.

Зураг 11. Том зээлдэгчдээ бусад банкинд алдахгүйн тулд танай банк зээлийн хүүний хөнгөлөлт үзүүлдэг үү?




Банкуудын ангиллаар үзвэл том банкууд бүгд, дундаж, жижиг банкуудын 70 хувь нь ийм зүйл байдаг гэж хариулжээ.

5. Зээлийн хүүг өөрчлөх/хэвээр нь үлдээх шийдвэр хэр тогтмол гардаг вэ?

Банкууд зээлийн хүүгээ өөрчлөхдөө бусад банкуудын үйл хөдлөлийг дагаж байна уу, эсвэл тодорхой давтамжтайгаар шийдвэрээ гаргаж байна уу гэдгийг тодорхойлохыг зорьсон.

Зураг 12. Зээлийн хүүг өөрчлөх/хэвээр нь үлдээх шийдвэр хэр тогтмол гардаг вэ?



Банкуудын 29 хувь нь зээлийн хүүний асуудлыг улирал болгон, 71 хувь нь тухайн үеийн эдийн засаг, санхүүгийн орчны нөхцөл байдлаас шалтгаалдаг хэмээн хариулжээ. Банкууд сар бүр зээлийн хүүг өөрчлөх буюу хэвээр үлдээх шийдвэрийн талаар хэлэлцдэггүй байна. Банкуудын ангиллаар үзвэл том банкуудын бүгд, дундаж банкуудын 75 хувь, жижиг банкуудын 71 хувь нь тодорхой давтамжгүйгээр, тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан шийдвэрээ гаргадаг гэжээ.

6. Өнөөгийн нөхцөлд зээлийн хүү буурлаа гэхэд хадгаламжийн хүүнд өөрчлөлт орох уу?

Өнөөгийн нөхцөл байдалд зээлийн хүү буурлаа гэхэд нийт банкуудын 36 хувь нь хадгаламжийн хүүгээ дагаад бууруулна, 64 хувь нь хадгаламжийн хүү буурахад нэлээдгүй хугацаа орно гэж хариулжээ.

Зураг 13. Өнөөгийн нөхцөлд зээлийн хүү буурлаа гэхэд хадгаламжийн хүүнд өөрчлөлт орох уу?



Банкуудын ангиллаар нь авч үзвэл том банкуудын 50 хувь, дундаж банкуудын 25 хувь, жижиг банкуудын 86 хувь хадгаламжийн хүү буурахад нэлээдгүй хугацаа орно гэж үзжээ.

7. Танай банк зээлийн хүүгээ бууруулахад нийт зээлийн хэмжээнд ямар өөрчлөлт гарч байсан бэ?

Зээлийн хүүнээс хамаарсан мэдрэмжийг ерөнхий байдлаар үнэлэхийн тулд тус асуултыг банкуудаас лавласан болно.

Хүүний түвшин буурахад зээлийн хэмжээ харьцангуй тогтвортой хэмжээнд байсан гэж банкуудын 64 хувь нь, зээлийн хэмжээ өссөн гэж 36 хувь нь хариулсан байна. Банкуудын ангиллаар үзвэл том банкууд бүгд зээлийн хэмжээ өссөн гэж хариулсан бол дундаж болон жижиг банкуудын 90 хувь нь зээлийн хэмжээ харьцангуй тогтвортой байсан гэж хариулжээ. Зээлийн хүүгээ бууруулахад нийт зээлийн хэмжээ буураагүй байна.

8. Зарим банк бодит үндэслэлгүйгээр зээлийн хүүг бууруулж, зах зээлийн бус хүү санал болгоод эхэлбэл танай банк ямар хариу үйлдэл хийх вэ?

Банкуудын 64 хувь нь энэ тохиолдолд зээлийн хүүндээ өөрчлөлт оруулахгүй, 36 хувь нь ямар нэг байдлаар хариу үйлдэл

хийнэ гэж хариулжээ. Тухайлбал, судалгаа хийсний үндсэн дээр өөрчлөх талаар шийдвэрлэнэ, өөр шинэ бүтээгдэхүүн санаачлан нэвтрүүлнэ, тодорхой төрлийн зээлийн хүүгээ бууруулна гэсэн байна.

9. Танай банкны зээлийн хүүний талаарх 2012 оны төсөөллөөсөө бидэнтэй хуваалцана уу?

Судалгаанд хамрагдсан банкуудын 36 хувь нь зээлийнхээ хүүг бууруулна, 36 хувь нь өөрчлөлт оруулахгүй, 28 хувь нь зээлийн хүүгээ өсгөнө гэсэн хариултыг сонгосон байна.

10. Банкуудын зээлийн хүүг бууруулахын тулд Монголбанк нэн түрүүнд ямар арга хэмжээ авах ёстой вэ?

Том банкууд Монголбанк инфляцийг бага түвшинд тогтвортой барих, бодлогын хүүг бууруулах, иргэдийн хадгаламжаас бусад бага зардалтай эх үүсвэрийг татан төвлөрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чухалчлан үзэж байсны зэрэгцээ, төгрөгийн бенчмарк бий болгох, зээлийн мэдээллийн санг баяжуулах, жижиг дунд бизнесийг дэмжсэн төслийн зээлийн санхүүжилтийг идэвхжүүлэх шаардлагатай гэж үзжээ. Дунд болон жижиг банкууд инфляци, бодлогын хүүний хувьд том банкуудтай адил саналтай байна. Мөн ЗБН-ийн хувийг бууруулах, дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх, гадаад валютын нөөцөөс урт хугацаатай эх үүсвэр бий болгоход туслах зэрэг саналуудыг дурьджээ.

11. Зээлийн хүүн дээр Монголбанкнаас дээд хязгаар тогтоох нь зөв үү?

Зээлийн хүүнд Монголбанкнаас дээд хязгаар тогтоохыг санал асуулгад оролцсон бүх банкууд буруу гэж үзжээ.

ДҮГНЭЛТ

Монголбанк арилжааны банкуудаас хадгаламж, зээлийн хүүний талаарх санал асуулгыг 2011 оны 10 дугаар сард авч нэгтгэн үр дүнг танилцууллаа. Энэхүү санал асуулгад үйл ажиллагаа явуулж буй арилжааны 14 банк оролцсон бөгөөд хадгаламж татдаггүй гэсэн шалтгаанаар Чингис хаан банкнаас хадгаламжийн хүүний талаар санал аваагүй болно.

1. Нийт хадгаламжийн хэмжээ 2009 оны 1 дүгээр сараас тогтмол бага зэргээр өсч байсан хэдий ч 2010 оны 12 дугаар сараас эрс нэмэгдэж 2011 оны 11 дүгээр сарын байдлаар 3.8 их наяд төгрөгт хүрсэн нь хөрөнгийн урсгалын хэмжээ эрс нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөн банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 64.0 хувиар нэмэгдэж 2011 оны 11 дүгээр сарын байдлаар 5.1 их наяд төгрөгт хүрчээ.

- 2010 оны 11 дүгээр сараас хадгаламжийн бодит хүү сөрөг (11-р сард -0.7%, 12-р сард -3.6%, 1-р сард -4.1%, 2-р сард -0.3%, 2011 оны 11 дүгээр сард -0.1) утгатай гарсан нь тухайн саруудад инфляци өндөр байсан холбоотой байна. Харин зээлийн хүүний хандлага хадгаламжийн нэрлэсэн хүүний хандлагатай адил байв.
- Банкны салбарын хэмжээнд 2011 оны 10 дугаар сарын байдлаар нийт хадгаламж эзэмшигчдийн 99.4% нь 50

сая төгрөг хүртэл, 0.3% нь 50-100 сая төгрөг, 0.3% нь 100 сая төгрөгөөс дээш төгрөгийн хадгаламж эзэмшдэг байна.

- Хадгаламжийн дүнгээр 52.5% нь 100 сая төгрөгөөс дээш, 37.9% нь 50 сая төгрөг хүртэл, 9.6% нь 50-100 сая төгрөгийн хадгаламж байна.
- Нийт хадгаламж эзэмшигчдийн хамгийн бага буюу 0.3 хувь нь 100 сая төгрөгөөс дээш хадгаламж эзэмшигч байгаа хэдий ч 100 сая төгрөгөөс дээш хадгаламжийн дүн нийт хадгаламжийн дийлэнх хувийг бүрдүүлсэн хэвээр байна.
- Том банкууд хадгаламжийн хүүгээ тогтоохдоо ихэвчлэн зах зээлийн өрсөлдөөн, инфляци, эх үүсвэр болон үйл ажиллагааны дундаж зардал, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан үздэг байна. Дундаж болон жижиг банкууд бусад банкны хадгаламжийн хүү, заавал байлгах нөөцийн хэмжээ эх үүсвэрийн өртгийг харгалзан үздэг.
- Арилжааны банкуудын дийлэнх нь эх үүсвэрийн зардал, эрсдэлийн түвшин, өрсөлдөгч банкуудын зээлийн хүү зэргийг харгалзан үзэж зээлийн хүүгээ тогтоодог байна. Мөн бодлогын хүү, инфляци, зээлтэй холбоотой зардлыг харгалзан үздэг байна.
- Хүү буурахгүй байгаа шалтгааныг банкууд хадгаламжаас өөр гадаад,

дотоодын хямд эх үүсвэр татах боломж хомс байгаатай холбон үзэж байна. Жижиг банкуудын хувьд банкуудын өрсөлдөөн их мөн банкны салбарт эзлэх хувийн жин бага тул эх үүсвэрээ тогтмол татаж байхын тулд хадгаламжийн хүүгээ бууруулах сонирхол байдаггүй байна.

- Зээлийн дундаж хугацаа богино байгаа нь эх үүсвэрийн дундаж хугацаа богино байгаатай холбоотой байна.
- Найдвартай зээлдэгч, том хадгаламж эзэмшигчээ алдахгүйн тулд банкууд хүүний хувьд уян хандаж өөр өөр хүү санал болгох явдал гардаг хэвээр байна.
- Банкууд хадгаламжийн хүүний асуудлыг тогтмол авч хэлэлцдэггүй бөгөөд зөвхөн тухайн үеийн эдийн засаг, санхүүгийн орчны нөхцөл байдлаас шалтгаалан авч үздэг байна.
- Банкуудын дийлэнх нь тодорхой давтамжгүйгээр, тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан зээлийн хүүндээ өөрчлөлт оруулах шийдвэрээ гаргадаг гэжээ.
- Монголбанкнаас хадгаламжийн хүү болон зээлийн хүүнд хязгаар тогтоохыг банкууд дэмжихгүй байна.

хүүг бууруулах, хөрөнгийн зах дээрх банкуудын оролцоох нэмэгдүүлэх, хямд үнэтэй, урт болон дунд хугацааны эх үүсвэрээр хангах, банкны салбарыг тогтвортой байлгах тал дээр анхаарч ажиллах, төгрөгийн бенчмарк бий болгох, банкуудыг зээлийн мэдээллээр тогтмол хангах, ЗБН-ийн хувийг бууруулах, дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх, эх үүсвэрийн өртгийг бууруулах, гадаад валютын нөөцөөс банкуудад урт хугацаатай эх үүсвэр бий болгоход туслах зэрэг арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

Банкууд Монголбанк хадгаламж болон зээлийн хүүг бууруулахын тулд инфляцийг тогтвортой бага түвшинд барих, бодлогын